

---

**МОНГОЛ УЛСЫН ГАДААД ХУДАЛДААНЫ  
ТЭНЦЭЛ, ГОЛ НЭР ТӨРЛИЙН ЭКСПОРТ,  
ИМПОРТЫН ТОО ХЭМЖЭЭ, ҮНЭ БОЛОН  
ТАТВАРЫН ОРЛОГО БҮРДЭЛТИЙН ТАЛААРХ  
ТОВЧ ТАНИЛЦУУЛГА**

---

Монгол Улсын Их Хурлын <http://parliament.mn/c/pwyo> цахим хаягаар, эсхүл дараах QR кодыг ашиглан бусад танилцуулга, мэдээтэй танилцана уу.




УЛСЫН ИХ ХУРЛЫН ТАМГЫН ГАЗРЫН  
ХЯНАЛТ ШАЛГАЛТ, ҮНЭЛГЭЭНИЙ ГАЗРЫН  
ТӨСВИЙН ХЯНАЛТ, ШИНЖИЛГЭЭНИЙ ХЭЛТЭС

**2023 он №ГХ8**

**МОНГОЛ УЛСЫН ГАДААД ХУДАЛДААНЫ ТЭНЦЭЛ, ГОЛ НЭР ТӨРЛИЙН  
ЭКСПОРТ, ИМПОРТЫН ТОО ХЭМЖЭЭ, ҮНЭ БОЛОН ТАТВАРЫН ОРЛОГО  
БҮРДЭЛТИЙН ТАЛААРХ ТОВЧ ТАНИЛЦУУЛГА  
(2023 ОНЫ ЭХНИЙ 8 САРЫН ГҮЙЦЭТГЭЛ)**

**ГАДААД ХУДАЛДАА  
(2023 оны эхний 8 сарын гүйцэтгэлээр)**



**Нэг. Гадаад худалдааны үзүүлэлт**

**Гадаад худалдааны нийт бараа эргэлт:** 2023 оны 8 дугаар сарын гүйцэтгэлээр гадаад худалдааны нийт бараа эргэлт 15,950.4 сая ам.доллар болж, өнгөрсөн оны мөн үеэс 19.6 хувь буюу 2,610.2 сая ам.доллароор өсөж, гадаад худалдааны тэнцэл 4,057.1 сая ам.долларын ашигтай гарсан байна.

**Хүснэгт 1. Гадаад худалдааны үзүүлэлт**

/сая ам.доллар/

Үзүүлэлт	ЭХНИЙ 8 САР (ЕССӨН ДҮНГЭЭР)				ӨӨРЧЛӨЛТ 2023/2022	
	2020	2021	2022	2023	Дүн	Хувь
Нийт эргэлтийн бараа	7,932.1	10,055.7	13,340.2	15,950.4	2,610.2	19.6
-Экспорт	4,478.9	5,581.7	7,740.6	10,003.7	2,263.1	29.2
-Импорт	3,453.2	4,474.0	5,599.6	5,946.7	347.1	6.2
Тэнцэл	1,025.6	1,107.7	2,141.0	4,057.1	1,916.1	89.5

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

**Гадаад худалдааны тэнцэл:** 2023 оны эхний 8 сарын гүйцэтгэлээр гадаад худалдааны тэнцэл 4,057.1 сая ам.долларын ашигтай гарсан байна. Өмнөх оны мөн үеэс 1,916.1 сая ам.доллароор өсөхөд экспорт 2,263.1 сая ам.доллароор өссөн нь голлон нөлөөлсөн байна.

**Экспорт:** 2023 оны эхний 8 сарын гүйцэтгэлээр 10,003.7 сая ам.доллар болж, 2022 оны мөн үтэй харьцуулахад 2,263.1 сая ам.доллар буюу 29.2 хувиар өссөн байна.

**Импорт:** 2023 оны эхний 8 сарын гүйцэтгэлээр импорт 5,946.7 сая ам.долларт хүрч, 2022 оны мөн үтэй харьцуулахад 347.1 сая ам.доллар буюу 6.2 хувиар өссөн байна.

### Хоёр. Гол нэр төрлийн экспортын бүтээгдэхүүн

Нийт экспортын 86.2 хувиig эрдсийн бүтээгдэхүүний экспорт, 13.2 хувиig эрдсээс бусад бүтээгдэхүүний экспорт эзэлж байна. Эрдсийн бүтээгдэхүүний экспорт 8,678.5 сая ам.доллар болж, өмнөх оноос 2,008.4

сая ам.доллар буюу 30.1 хувиар өссөн бол эрдсийн бус бүтээгдэхүүний экспорт 1,325.3 сая ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 239.3 сая ам.доллар буюу 22.0 хувиар өссөн байна.

#### Хүснэгт 2. Эрдсийн болон эрдсийн бус бүтээгдэхүүний экспорт

/сая ам.доллар/

Үзүүлэлт	Эхний 8 сар (өссөн дүнгээр)				Өөрчлөлт		Нийт экспортод эзлэх хувь
	2020	2021	2022	2023	Дүн	Хувь	
Эрдсийн бүтээгдэхүүний экспорт	3,026.8	4,730.3	6,670.1	8,678.5	2,008.4	30.1	86.8
Эрдсээс бусад бүтээгдэхүүний экспорт	1,452.1	896.5	1,086.0	1,325.3	239.3	22.0	13.2
<b>Нийт экспорт</b>	<b>4,478.9</b>	<b>5,626.8</b>	<b>7,756.1</b>	<b>10,003.7</b>	<b>2,247.7</b>	<b>29.0</b>	<b>100.0</b>

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

### ЭКСПОРТЫН ЗАРИМ ГОЛ НЭРИЙН БАРААНЫ ТОО ХЭМЖЭЭ БОЛОН ҮНИЙН ДҮН

Чулуун нүүрс, зэсийн баяжмал, төмрийн хүдэр, цайрын баяжмал, хайлуур жонш, боловсруулаагүй нефть, боловсруулаагүй

буюу хагас боловсруулсан алт зэрэг уул уурхайн бүтээгдэхүүн нь нийт экспортын 86.8 хувииг эзэлсэн байна.

#### Хүснэгт 3. Гол нэр төрлийн бүтээгдэхүүний экспортын тоо хэмжээ, төрлөөр

Барааны төрөл	Хэмжих нэгж	Эхний 8 сар (өссөн дүнгээр)				Өмнөх оны мөн үеэс	
		2020	2021	2022	2023	Дүн	Хувь
Зэсийн баяжмал	мян.тн	905.4	893.4	976.8	1,022.3	45.5	4.7
Нүүрс	сая.тн	15.2	11.0	14.7	40.9	26.2	178.4
Төмрийн хүдэр	сая.тн	5.6	5.3	2.7	3.7	1.0	37.6
Цайрын баяжмал	мян.тн	88.8	85.5	97.1	119.3	22.2	22.9
Алт	тн	19.9	5.8	9.9	6.8	-3.2	-31.7
Боловсруулаагүй нефть	сая.баррель	1.8	3.6	0.9	3.2	2.2	
Катодын зэс	тн	6.0	7.0	4.8	8.5	3.7	77.9
Жоншны баяжмал	мян.тн	370.5	524.2	204.1	624.1	420.0	205.8
Адууны мах	мян.тн	5.7	7.1	0.9	18.4	17.5	2003.0
Өлөн гэдэс	тн	339.1	388.2	367.4	291.2	-76.2	-20.8

Үхэр, адууны боловсруулсан шир	сая.дм2	21.5	7.5	4.0	10.0	6.0	147.9
Үхэр, адууны боловсруулаагүй шир	мян.ш	72.7	441.4	34.8	254.6	219.8	631.8
Хонь, хурганы боловсруулсан арьс	сая.дм2	40.7	66.3	13.5	37.4	23.9	
Ямаа, ишигний боловсруулсан арьс	сая.дм2	75.4	65.6	53.7	42.7	-11.0	-20.4
Самнасан ноолуур	тн	162.6	226.7	484.0	601.2	542.3	920.9
Бохир ноолуур	тн	4,405.7	5,021.6	5,362.1	4,562.3	-799.8	-14.9
Хонины самнаагүй ноос	мян.тн	3.6	5.7	9.1	7.8	-1.3	-14.5

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

#### Хүснэгт 4. Гол нэр төрлийн бүтээгдэхүүний экспортын орлого

/сая ам.доллар/

Барааны төрөл	Эхний 8 сар (өссөн дунгээр)				Өмнөх оны мөн үеэс	
	2020	2021	2022	2023	Дүн	Хувь
Зэсийн баяжмал	1,011.0	1,993.0	1,993.4	1,775.0	-218.4	-11.0
Нүүрс	1,167.0	1,292.4	3,851.8	5,734.8	1.9	48.9
Төмрийн хүдэр	402.5	768.1	255.9	286.4	30.5	11.9
Цайрын баяжмал	105.7	131.0	201.6	182.9	-18.8	-9.3
Алт	1,146.5	338.4	591.4	425.5	-165.8	-28.0
Боловсруулаагүй нефть	66.8	218.8	103.4	237.1	133.7	129.3
Катодын зэс	32.4	62.3	43.2	71.3	28.1	64.9
Жоншны баяжмал	88.0	114.3	58.7	155.7	97.1	165.4
Адууны мах	10.8	14.6	2.6	68.9	66.3	2531.5
Өлөн гэдэс	5.5	9.1	9.2	5.7	-3.5	-38.1
Үхэр, адууны боловсруулсан шир	2.1	0.8	0.38	0.65	0.3	0.0
Үхэр, адууны боловсруулаагүй шир	0.1	0.7	0.22	0.72	0.5	224.0
Хонь, хурганы боловсруулсан арьс	0.9	1.3	0.2	0.6	0.4	0.2
Ямаа, ишигний боловсруулсан арьс	2.7	2.2	1.2	1.1	-0.1	-5.1
Самнасан ноолуур	11.0	19.2	53.9	57.7	3.9	7.2
Бохир ноолуур	129.4	197.3	255.9	222.4	-33.6	-13.1
Хонины самнаагүй ноос	3.2	5.9	6.6	8.2	1.6	23.6

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

#### Хүснэгт 5. Эрдэс бүтээгдэхүүний экспортын дундаж үнэ

/ам.доллар/

Барааны нэр	Хэмжих нэгж	8 дугаар сар		Өөрчлөлт	
		2022	2023	Зөрүү	Хувь
Чулуун нүүрс	тн/ам.дол	260.1	140.2	-119.9	-46.1%
Зэсийн баяжмал	тн/ам.дол	2,040.6	1,736.2	-304.4	-14.9%
Төмрийн хүдэр, баяжмал	тн/ам.дол	96.2	78.3	-18.0	-18.7%
Цайрын хүдэр, баяжмал	тн/ам.дол	2,076.4	1,532.6	-543.9	-26.2%
Жоншны хүдэр, баяжмал	тн/ам.дол	287.6	249.5	-38.1	-13.2%
Алт	тн/ам.дол	59,432.5	62,600.5	3,168.0	5.3%

Эх сурвалж: Уул уурхайн яам

**Эрдсийн бүтээгдэхүүний экспорт** өнгөрсөн оны мөн үеэс 2,008.4 сая ам.доллар буюу 30.1 хувиар өсөхөд голлон нөлөөлсөн бүтээгдэхүүнүүдийг авч үзвэл:

**1. Нүүрс:** 2023 оны эхний 8 сарын байдлаар 5,823.4 сая ам.долларын 42,640.5 мян.тн нүүрс экспортолсон байна. Өнгөрсөн оны мөн үеэс үнийн дунгээр 1,957.3 сая ам.доллар буюу 50.6 хувиар, биет хэмжээгээр 27,770.0 мян.тн буюу 2.9 дахин тус тус өссөн байна.

Чулуун нүүрсний 99.2 хувийг БНХАУ, 0.5 хувийг Сингапур, 0.3 хувийг БНСУ руу тус тус экспортолсон байна.

**2.Зэсийн баяжмал:** 2023 оны эхний 8 сарын байдлаар 1,775.0 сая ам.долларын 1,022.3 мян.тн зэсийн баяжмал экспортолсон байна. Өнгөрсөн оны мөн үеэс үнийн дүнгээр 218.4 сая ам.долларбуюу 11.0 хувиар буурсанч, биет хэмжээгээр 45.5 мян.тн буюу 4.7 хувиар ёссөн байна. Зэсийн баяжмалыг 99.9 хувийг БНХАУ, 0.1 хувийг Сингапур улс руу тус тус экспортолсон байна.

**3.Цайрын баяжмал:** 2023 оны эхний 8 сарын байдлаар 182.9 сая ам.долларын 119.3 мян.тн цайрын баяжмал экспортолсон байна. Өнгөрсөн оны мөн үеэс биет хэмжээгээр 21.9 мян.тн буюу 22.5 хувиар ёссөн ч, үнийн дүнгээр 19.4 сая ам.доллар буюу 9.6 хувиар буурсан байна. Цайрын баяжмалыг 100 хувь БНХАУ руу экспортолсон байна.

**4.Алт:** 2023 оны эхний 8 сарын байдлаар 425.5 сая ам.долларын 6,797.8 кг алт экспортолсон байна. Өнгөрсөн оны мөн үеэс үнийн дүнгээр 165.8 сая ам.доллар буюу 28.0 хувиар, биет хэмжээгээр 3,152.3 кг буюу 31.7 хувиар тус тус буурсан байна. Алтны 82.0 хувийг Швейцар, 18.0 хувийг БНСУ руу тус тус экспортолсон байна.

### Гурав. Гол нэр төрлийн импортын бүтээгдэхүүн

Нийт импортын 24.1 хувийг эрдсийн бүтээгдэхүүний импорт, 75.9 хувийг эрдсээс бусад бүтээгдэхүүний импорт тус тус эзэлж байна.

Эрдсийн бүтээгдэхүүний импорт 1,431.5 сая ам.долларт хүрч өмнөх оны мөн үеэс 189.4 сая ам.доллараар буюу 15.3 хувиар

ёссөн байна. Эрдсээс бусад бүтээгдэхүүний импорт 4,515.2 сая ам.долларт хүрч, өнгөрсөн оны мөн үеэс 157.5 сая ам.доллар буюу 3.6 хувиар ёссөн байна.

#### Хүснэгт 6. Эрдсийн болон эрдсээс бусад бүтээгдэхүүний импорт

/сая ам.доллар/

Үзүүлэлт	8 дугаар сар (ёссөн дүнгээр)						Нийт импортоод эзлэх хувь
	2020	2021	2022	2023	Дүн	Хувь	
Эрдсийн бүтээгдэхүүний импорт	654.3	794.7	1,242.0	1,431.5	189.4	15.3	24.1
Эрдсээс бусад бүтээгдэхүүний импорт	2,798.9	3,679.2	4,357.7	4,515.2	157.5	3.6	75.9
Нийт импорт	3,453.2	4,473.9	5,599.7	5,946.7	347.0	6.2	100.0

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

Импортын барааны бүтцийн хувьд эрдэс бүтээгдэхүүн 24.1 хувь, машин механик тоног төхөөрөмж ба эд анги, цахилгаан хэрэгсэл, тэдгээрийн сэлбэг 18.9 хувь, авто болон агаарын тээврийн хэрэгсэл, тэдгээрийн эд анги 18.1 хувь, мал амьтан, ургамлын гаралтай бүтээгдэхүүн, хүнсний

зүйл 10.7 хувь, химийн болон түүнтэй холбоотой үйлдвэрийн бүтээгдэхүүн 5.4 хувь, үндсэн төмөрлөг болон түүгээр хийсэн бүтээгдэхүүн 9.4 хувийг тус тус эзэлж байна.

## Хүснэгт 7. Импортын гүйцэтгэл, барааны бүлгээр

/сая ам.доллар/

№	Барааны нэр	Импорт		Өөрчлөлт		Нийт импортод эзлэх хувь
		2022.08	2023.08	Дүн	Хувь	
1	Амьд мал, амьтад, мал амьтдын гаралтай бүтээгдэхүүн	99.7	94.2	-5.5	-5.5	1.6
2	Ургамлын гаралтай бүтээгдэхүүн	98.6	97.6	-1.0	-1.0	1.6
3	Мал амьтны болон ургамлын гаралтай тос, өөх	33.0	22.6	-10.4	-31.5	0.4
4	Хүнсний бэлэн бүтээгдэхүүн	511.2	419.6	-91.5	-17.9	7.1
5	<b>Эрдэс бүтээгдэхүүн</b>	<b>1,242.0</b>	<b>1,431.5</b>	<b>189.4</b>	<b>15.3</b>	<b>24.1</b>
6	Химийн болон түүнтэй холбоотой үйлдвэрийн бүтээгдэхүүн	377.5	323.9	-53.6	-14.2	5.4
7	Хуванцар болон түүгээр хийсэн зүйлс; хаймар болон түүгээр хийсэн зүйлс	226.1	233.3	7.2	3.2	3.9
8	Арьс ширэн түүхий эд болон боловсруулсан арьс, шир, ангийн үс, эдгээрээр хийсэн эдлэл	6.3	6.5	0.3	4.4	0.1
9	Мод, модон эдлэл	58.7	49.4	-9.2	-15.8	0.8
10	Цаас болон картон, тэдгээрээр хийсэн зүйлс	66.9	51.5	-15.4	-23.0	0.9
11	Нэхмэлийн материал болон нэхмэл эдлэл	86.9	96.2	9.2	10.6	1.6
12	Гутал, малгай, төрөл бүрийн бусад зүйл	21.6	22.8	1.2	5.4	0.4
13	Чулуу, гөлтгөнө, шөрмөсөн чулуу, гялтгануур болон тэдгээртэй төстэй материалаар хийсэн бүтээгдэхүүн	156.2	148.7	-7.5	-4.8	2.5
14	Сувд, үнэт ба хагас үнэт чулуу, үнэт металл, гоёлын зүйлс, зоос	5.7	3.5	-2.2	-38.1	0.1
15	Үндсэн төмөрлөг болон түүгээр хийсэн бүтээгдэхүүн	557.4	561.3	3.9	0.7	9.4
16	Машин, механик тоног төхөөрөмж ба эд анги, цахилгаан хэрэгсэл, тэдгээрийн сэлбэг	846.3	1,122.0	275.7	32.6	18.9
17	Авто, агаарын ба усан замын тээврийн хэрэгсэл, тэдгээрийн эд, анги	1,013.2	1,077.5	64.3	6.3	18.1
18	Хараа зүй, гэрэл зураг, хэмжүүр, хяналт, эмнэлгийн багаж хэрэгсэл, цаг, хөгжмийн зэмсэг эдгээрийн эд анги	93.4	84.1	-9.3	0.0	0.0
19	Аж үйлдвэрийн төрөл бүрийн бараа	97.6	98.6	0.9	0.0	0.0
20	Урлагийн бүтээл, цуглуулга хийх, зориулалтын зүйлс ба эртний үнэт дурсгалын зүйлс	0.1	0.1	0.0	0.0	0.0
21	Бусад	1.3	1.9	0.6	0.0	0.0
	<b>ДҮН</b>	<b>5,599.6</b>	<b>5,946.7</b>	<b>347.1</b>	<b>6.2</b>	<b>100.0</b>

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

Эрдэс бүтээгдэхүүний импортын үнийн дүнгийн 87.6 хувийг газрын тосны бүтээгдэхүүн эзэлж байна.

2023 оны эхний 8 сарын байдлаар 1,254.1 сая ам.долларын 1,607.9 мян.тн газрын тосны бүтээгдэхүүн импортолсон нь өнгөрсөн оны мөн үеэс биет хэмжээгээр 435.8 мян.тн буюу 37.2 хувиар, үнийн дүнгээр 166.6 сая ам.доллар буюу 15.3 хувиар тус тус өссөн байна.

Газрын тосны бүтээгдэхүүний импортын нийт үнийн дүнгийн 88.0 хувийг автобензин, дизель түлшний импорт, үүний 29.2 хувийг автобензин, 58.8 хувийг дизель түлшний импорт тус тус эзэлж байна.

## Дөрөв. Улсын төсвийн гаалийн орлого бүрдэлт

Гаалийн байгууллага нь 2023 оны эхний 8 сард 3,511.7 тэрбум төгрөг төвлөрүүлэхээс 3,399.8 тэрбум төгрөгийн гүйцэтгэлтэйгээр

буюу 96.8 хувиар буюу 112.0 тэрбум төгрөгөөр тасарсан үзүүлэлттэй байна.

### Хүснэгт 8. Татварын орлогын гүйцэтгэл

/тэрбум төгрөг/

Үзүүлэлт	2022.08	2023.08		Өмнөх оны мөн үетэй харьцуулахад		Төлөвлөгөөтэй харьцуулахад	
	Гүйц.	Төл.	Гүйц.	Зөрүү	Хувь	Зөрүү	Хувь
<b>НИЙТ ОРЛОГО</b>	2,989.6	3,511.7	3,399.8	410.2	113.7	-111.9	96.8
<b>Өөрийн орлого</b>	11.7	11.1	19.8	8.1	169.2	8.7	178.4
<b>Хураамж</b>	30.8	45.8	79.8	49.0	259.1	34.0	174.2
<b>Татварын дүн</b>	2,947.1	3,454.9	3,300.2	353.1	112.0	-154.7	95.5
Гаалийн албан татвар	822.5	1020.6	934.5	112.0	113.6	-86.1	91.6
Нэмэгдсэн өртгийн албан татвар	1,711.8	2,063.2	2,016.9	305.1	117.8	-46.3	97.8
Архи, дарсны онцгой албан татвар	16.5	22.4	20.7	4.2	125.5	-1.7	92.4
Тамхины онцгой албан татвар	92.9	92.8	93.2	0.3	100.3	0.4	100.4
Шар айрагны онцгой албан татвар	4.7	4.5	4.9	0.2	104.3	0.4	108.9
Суудлын автомашины онцгой албан татвар	203.2	176.6	203.6	0.4	100.2	27.0	115.3
Автобензин, дизель түлшний онцгой албан татвар	83.2	59.6	11.3	-71.9	13.6	-48.3	19.0
Автобензин, дизель түлшний албан татвар	12.4	15.2	15.0	2.6	121.0	-0.2	98.7
Экспортын татвар	0.005		0.0	0.0	0.0	0.0	0.0

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

Орлогын гүйцэтгэлийг өнгөрсөн онтой харьцуулбал нийт орлого өнгөрсөн оны мөн үеэс 410.2 тэрбум төгрөгөөр буюу 13.7 хувиар өссөн байна. Үүнээс:

- Гаалийн албан татвар 112.0 тэрбум төгрөг,
- Нэмэгдсэн өртгийн албан татвар 305.1 тэрбум,
- Архи, дарсны онцгой албан татвар 4.2 тэрбум төгрөг,
- Тамхины онцгой албан татвар 0.3 тэрбум төгрөг,
- Шар айрагны онцгой албан татвар 0.2 тэрбум төгрөг,
- Автобензин дизелийн түлшний албан татвар 2.6 тэрбум төгрөг,
- Өөрийн орлого 8.1 тэрбум төгрөг,
- Хураамжийн орлого 49.0 тэрбум төгрөгөөр тус тус өссөн.

Харин суудлын автомашины онцгой албан татвар 0.4 тэрбум төгрөг, автобензин, дизелийн түлшний онцгой албан татвар 71.9 тэрбум төгрөгөөр тус тус буурсан байна.

**Зарим төрлийн импортын бараанд ногдуулсан онцгой албан татварын орлого бүрдэлт, импортын тоо хэмжээний талаар:**

Онцгой албан татвартай суудлын автомашин: Тайлант хугацаанд онцгой албан татвартай суудлын автомашин 46625 ширхгийг импортолсон нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 816 ширхэг буюу 1.7 хувиар буурсан үзүүлэлттэй байна. Үүнээс хос тэжээлт болон шингэрүүлсэн хийгээр ажилладаг суудлын автомашин 1137 ширхгээр өссөн бол, бусад суудлын автомашин 1953 ширхгээр буурсан.

**Хүснэгт 9.** Онцгой албан татвартай суудлын автомашины импортын тоо хэмжээ, ногдуулсан татвар

Төрөл	Импортын тоо хэмжээ /ширхэг/				Ногдуулсан татвар /тэрбум төгрөг/			
	2022.08	2023.08	Зөрүү	Хувь	2022.06	2023.06	Зөрүү	Хувь
Хос тэжээлт	35,056.0	36,193.0	1,137.0	103.2%	129.8	147.0	17.3	113%
Бусад	12,385.0	10,432.0	-1,953.0	84.2%	73.8	56.8	-17.1	77%
<b>Нийт</b>	<b>47,441.0</b>	<b>46,625.0</b>	<b>-816.0</b>	<b>98.3%</b>	<b>203.5</b>	<b>203.8</b>	<b>0.2</b>	<b>100%</b>

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

Монгол улс шатахууны хэрэгцээгээ 100 хувь импортоор хангаж байгаа бөгөөд 2022 оны эхний 8 сард 1047.69 мянган тн, 2023 оны эхний 8 сард 1452.1 мянган тн автобензин, дизелийн түлшний бүтээгдэхүүн импортолсон байна.

**Хүснэгт 10.** Автобензин, дизелийн түлшний импортын тоо хэмжээ, ногдуулсан татвар

Төрөл	Импортын тоо хэмжээ /мян.тонн/				Ногдуулсан татвар /тэрбум төгрөг/			
	2022.08	2023.08	Зөрүү	Хувь	2022.06	2023.06	Зөрүү	Хувь
Нийт	1,047.7	1,452.1	404.4	138.6%	62.5	2.6	-59.8	4.2%
Автобензин	A-80	26.8	19.1	-7.6	71.3%	0.0	0.0	0.0%
	A-92	0.2	479.8	479.6	-	0.0	0.0	0.0%
	A-95 болон түүнээс дээш	397.8	12.7	-385.1	3.2%	0.0	2.6	2.6
Газрын тосны үйлдвэрлэлийн дайвар бүтээгдэхүүн, керосин	-	-	-	-	1.5	0.0	-1.5	-
Дизель түлш	622.9	940.4	317.6	151.0%	61.0	0.0	-61.0	0.0%

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

## Тав. Татварын чөлөөлөлт

2023 оны эхний 8 сард нийт импортод татвартай импорт 93.6 хувь, татвараас чөлөөлөгдсөн импорт үнийн дүнгээрээ 6.4 хувийг тус тус эзэлж байна. Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад татвартай импорт 3,334.2 тэрбум төгрөгөөр буюу 21.5 хувиар өссөн бол, татвараас чөлөөлөгдсөн

импорт 330.3 тэрбум төгрөгөөр буюу 33.8 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Татвараас чөлөөлөгдсөн импортын нийт импортод эзлэх хувь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 3.5 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

### Хүснэгт 11. Импортын бүтэц

/тэрбум төгрөг/

Үзүүлэлт	2022.08	2023.08	Өөрчлөлт (+,-)	Хувиар
Татвартай импорт	15,889.5	19,223.8	3,334.2	121.0%
Эзлэх хувь	97.1%	93.6%	-3.5%	
Татвараас чөлөөлөгдсөн импорт	976.0	1,306.3	330.3	133.8%
Эзлэх хувь	16,865.5	20,530.0	3,664.5	121.7%

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

УЛСЫН ИХ ХУРЛЫН ТАМГЫН ГАЗРЫН  
ХЯНАЛТ ШАЛГАЛТ, ҮНЭЛГЭЭНИЙ ГАЗРЫН  
ТӨСВИЙН ХЯНАЛТ, ШИНЖИЛГЭЭНИЙ ХЭЛТЭС